



ТИПОЛОГ- ИЙН ТАЙЛАН

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт
бодисыг хууль бусаар худалдаалж
олсон орлогыг угаах нь



ТИПОЛОГИЙН ТАЙЛАН

Мансууруулах эм, сэтгэцэд
нөлөөт бодисыг хууль бусаар
худалдаалж олсон орлогыг
угаах нь

АГУУЛГА

01

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдаалж олсон орлогыг угаах нь

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэж юу вэ?

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдаалах гэмт хэрэг

02

Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал

Монгол Улсын хууль, эрх зүйн тогтолцоо

Тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдаалах гэмт хэрэг Монгол Улсад

03

Түгээмэл типологиуд

04

Кэйс жишээ

Жишээ 1. Трамадолын хууль бус наймаа болон мөнгө угаах үйл ажиллагаа

Жишээ 2. Сэжигтэй гүйлгээгээр урьдал химийн бодисын худалдан авалтыг тодорхойлсон нь

Жишээ 3. Онлайн эмийн компани болон ХСМУ ашигласан нь – Энэтхэг Улс

05

Авах арга хэмжээ

06

Сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэхэд анхаарах зүйлс

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ВХ	Виртуал хөрөнгө
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ЛСД	Лизергик хүчлийн диэтиламид
МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
МУТС	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
ОХУ	Оросын Холбооны Улс
СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ҮЭҮ	Үндэсний эрсдэлийн үнэлгээ
ФАТФ	Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХБННУ	Холбооны Бүгд Найрамдах Нигер Улс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР ХУДАЛДААЛЖ ОЛСОН ОРЛОГЫГ УГААХ НЬ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэж юу вэ?

Олон улсад болон манай оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд дурдсанаас үзвэл “мансууруулах бодис” гэдэгт Мансууруулах эмийн тухай НҮБ-ын 1961 оны нэгдсэн конвенц (1972 оны протоколоор оруулсан нэмэлт, зааврын хамт), түүний 1, 2 дугаар жагсаалтад (Хавсралт 1) заасан эмийн найрлагаас агуулсан, байгалийн болон нийлэгжүүлж гаргаж авсан бөгөөд онцгой төрлийн мансууруулах үйлчилгээ үзүүлж, хүч тамир барагдуулдаг, удаан хэрэглэвэл сэтгэцийн өвчнөөр өвчлүүлдэг бодисуудыг хамааруулан ойлгодог байна.

Мансууруулах бодисын тоонд бидний нэрлэж заншсанаар хар тамхи буюу опиоидын гаралтай мансууруулах бодисууд мөн ордог. Хар тамхи гэдэг нь опиоидуудад оноож өгсөн хар ярианы хэллэг бөгөөд албан ёсны баримт бичигт хэрэглэгдэх шинжлэх ухааны нэр томьёо биш юм. (Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс, 2013)

Харин “Сэтгэцэд нөлөөлөх бодис” гэдэгт сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын 1971 оны Конвенцын 1, 2, 3, 4-р хавсралтад (Хавсралт 2) орсон байгалийн болон нийтлэг аливаа бодисуудыг ойлгодог байна. Эмх замбараагүй хэрэглээнээс бий болох эрүүл мэндийн болон нийгмийн сөрөг үр дагаврыг харгалзан, мансууруулах үйлчилгээтэй бодис болохыг нь тогтоож, хяналтаас гадуур (эмнэлэг, судалгаа шинжилгээний бус зорилгоор) хэрэглэхийг хориглон, тусгай жагсаалтад оруулсан бодис, эм, бэлдмэлүүдийг хууль эрх зүйн үүднээс мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт бодис хэмээн тооцдог байна.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн зохицуулалтын товч түүх:



1) 1800-1959 он /Каннабис, опиумын хэрэглээг хуулиар зохицуулж, мансууруулах бодисыг нийлэгжүүлснээр эмчилгээнд хэрэглэж эхэлсэн үе/

1800 онд Наполеон Египетэд дайтаж байхдаа өөрийн цэргүүддээ каннабисын ургамал хэрэглэхийг хориглосон зарлиг гаргасан бол 1858 онд Нэгдсэн Вант Улсад Хорын тухай хууль /Passage of the Poisons Act/-ийг гаргаж, хүний амийг хөнөөх зорилгоор хор өгөх, нийлүүлэхийг хориглосон хууль гарсан нь орчин цагийн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой эрх зүйн үндсийг тавьсан байна.

2) 1960-1996 он /Аюултай мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлт газар авч, НҮБ-ын 3 конвенц батлагдаж, хориглох, эсэргүүцлийн арга хэмжээ өрнөсөн үе/

1961 онд НҮБ-ын Мансууруулах эмийн тухай конвенц батлагдаж, эмнэлгийн болон судалгааны зорилгоос (Хавсралт 3) бусад тохиолдолд опиоид, каннабинойд ба кокайныг хориглож, бодисуудыг 1-4 дүгээр жагсаалтад оруулсан бол 1971 онд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцыг баталж, шинэ бодисуудыг оруулж, өргөжүүлсэн. 1988 онд Мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц батлагдаж, олон улсын хамтын ажиллагааны зарчмуудыг тодорхойлжээ.

3) 1997-2007 он /Өмнөх арга хэмжээнд дүгнэлт өгч шинэ стратеги, эрх зүйн орчныг бий болгосон үе/

Энэ үед мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэж, шинэ стратегийг бий болгосон юм.

Тухайлбал, 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар тусгай хуралдааныг хийж “.....хар тамхины тариалалт, ургацын хэмжээг үлэмж бууруулснаар 2008 он гэхэд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эсрэг томоохон ахиц дэвшил гаргасан байх” тухай дурджээ.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдаалах гэмт хэрэг



НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас 2022 онд гаргасан Дэлхийн мансууруулах бодисын тайлан (World drug report)-д дурдсанаар дэлхий дахинд дэлгэрээд буй опиоид буюу мансууруулах бодис (опиумын намуу цэцгээс болон лаброторын аргаар гаргаж авсан нэгэн төрлийн мансууруулах бодис)-ыг эмчилгээний бус зориулалтаар ашиглаж буй 2 том тархалтыг онцолсон байна. Энэ нь Хойд Америкт хууль бусаар гаргаж авч буй фентанил болон Умард, Өмнөд Африк, Ойрх Дорнод, Зүүн Өмнөд Азийн орнуудад нийтлэг худалдаалагдаж буй трамадол юм. (ФАТФ, 2022)

Олон улс орнууд эдгээр мансууруулах төрлийн бодисуудыг өөрсдөө үйлдвэрлэдэггүй ч синтетик опиоидыг гаргаж авахад ашигладаг урьдал бодисууд (precursor chemicals) болон тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх эсвэл дамжуулан өнгөрүүлэхэд оролцдог байна.

Үүний зэрэгцээ, уламжлалт мансууруулах бодисын наймаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь хууль бус синтетик мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын худалдааг илүү өргөн хүрээний худалдаанд оруулж, нийлүүлэлтийн сүлжээнд оролцдоггүй улс орнуудын санхүүгийн системийг ашиглан гэмт хэргээс олсон орлогыг угаадаг байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-аас 2013 оноос хойш хийж буй 4 дэх удаагийн Харилцан үнэлгээнд хамрагдсан нийт улс, орнуудын гуравны хоёр нь мөнгө угаах эрсдэл дагуулж буй томоохон суурь гэмт хэргийн нэгээр мансууруулах бодис худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон байна (ФАТФ, 2022). Мөн сүүлийн үед зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн мансууруулах бодисоос олсон орлогоо угаах бизнес модельд ихээхэн өөрчлөлт орж байгаа тул зарим улс, орнуудын мөнгө угаах эрсдэлд томоохон нөлөө үзүүлж байна. Тухайлбал, дараах чиг хандлагууд ажиглагдаж байна. Үүнд:

Синтетик мансууруулах төрлийн бодисыг гаргаж авахад ашиглагддаг урьдал бодисууд болон үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтын өөрчлөлтүүд;

Хууль бус үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн урсгалыг төөрөгдүүлж, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийг мөнгө угаах гэмт хэргээс холдуулдаг мэргэжлийн мөнгө угаах сүлжээнүүдийн олширол;

Дижитал төлбөрийн платформууд, тэр дундаа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид (ВХҮҮ)-ийн хууль бус мансууруулах бодис худалдан авах болон гэмт хэргээс олсон орлогыг угаах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг; зарим үйл ажиллагаа нь дарк веб (dark web)-ээр мөн түгээмэл хийгддэг байна.



Фентанилын худалдаа нь Хойд Америкт түгээмэл бөгөөд хууль бус зах зээл дээр героиныг бодвол бага үнээр худалдаалагддаг тул ихэвчлэн бусад төрлийн мансууруулах бодистой хамт хэрэглэгддэг байна. Энэ нь маш өндөр нөлөөтэй (героиноос 50, морфиноос 100 дахин хүчтэй) тул хэтрүүлэн хэрэглэх эрсдэл их гардаг гэсэн үг юм. Өндөр нөлөөний зэрэгцээ “тун”-д ногдох хэмжээ маш жижиг тул энэхүү мансууруулах бодисыг хялбар аргаар хууль бусаар нэвтрүүлэх боломжтой байдаг. Тухайлбал, нунтаг, хамрын шүршигч, чулуу, наалт, чихэртэй төстэй хэлбэр болон үрэл хэлбэрээр хэрэглэж болох бөгөөд тээвэрлэлт нь зардал багатай байдаг байна.

Синтетик мансууруулах бодисын наймаанаас олсон орлогын дийлэнх нь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдийн фентанил, трамадол зэрэг опиоидуудын борлуулалт хийгддэг улсад нь хуримтлагддаг. Гэсэн хэдий ч томоохон хэмжээний тээвэрлэлтийг удирдаж буй эдгээр гэмт хэргийн бүлэглэл рүү хууль бус мөнгө шилжихэд тухайн орлого болон бараа нь салж, орлого нь мөнгө угаах илүү төвөгтэй схемүүдээр дамжих боломжтой болдог.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хувьд үндсэн зардал нь опиоид буюу урьдал бодисуудыг хууль бусаар хил нэвтрүүлэх, олж авах, түүнчлэн синтетик мансууруулах бодисын нийлэгжүүлэлт (хэрэв нууцаар үйлдвэрлэсэн бол), үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон мэргэшсэн ажиллах хүчинтэй (химич) холбоотой байдаг. Энэ үйл явцад урьдал бодисыг хууль бусаар нэвтрүүлдэг завсрын улс орнууд болон компаниуд мөн оролцож болдог.



Мөнгө угаах үе шатуудын хувьд **байршуулах үйл явц** нь ихэвчлэн хэрэглэгч улс дотор явагддаг.

Нуун далдлах, буцаан төвлөрүүлэх үе шат нь харин бэлэн мөнгө хууль бусаар хил нэвтрүүлэх, халхавч компани, мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ (хавала гэх мэт) эсвэл худалдаанд суурилсан мөнгө угаах, эсвэл корреспондент банкны үйлчилгээг ашиглах гэх мэт арга замаар дамжин явагдах магадлалтай байдаг байна.

Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд гэмт хэргээс олсон орлогоо угаахын тулд мөнгө угаах мэргэжлийн сүлжээг мөн ашигладаг. Мэргэжлийн мөнгө угаагчдын гол зорилго нь үйлчлүүлэгчдэдээ “хөрөнгө, мөнгө” шилжүүлэхэд туслалцаа үзүүлэх явдал байдаг тул орлого олж буй гол хууль бус үйлдэлд оролцох нь ховор байдаг. Үүний оронд тэд хөрөнгийн мөн чанар, эх үүсвэр, байршил, эзэмшил, хяналт, гарал үүсэл ба/эсвэл очих газрыг нуун дарагдуулах үйлчилгээгээр хангаж мансууруулах бодисын бүлэглэл болон уламжлалт зохион байгуулалттай гэмт хэргийн байгууллагуудын нэрийн өмнөөс нарийн төвөгтэй, их хэмжээний мөнгө угаах үйл ажиллагааг явуулдаг.

Мөнгө угаах мэргэжлийн сүлжээнд нягтлан бодогч, банкир, хуульч багтаж болдог бөгөөд тэдгээр нь ихэвчлэн худалдааны компани эсвэл мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч, түүнчлэн тэдний халхавч болгон ашигладаг олон төрлийн хууль ёсны арилжааны аж ахуйн нэгжүүдийн эзэмшигч эсвэл тэдэнтэй холбоотой хүмүүс байдаг байна.

Олон улсад ургамлын болон синтетик гаралтай мансууруулах бодисын хууль бус үйлдвэрлэгч, наймаалагчийн хэд хэдэн том төвлөрөл бий гэж үздэгээс, үүнд:

1. “Алтан гурвалжин” (Тайланд, Лаос, Мьянмарын хилийн бүс),
2. “Алтан хавирган сар” (Афганистан, Пакистан, Ираны хилийн бүс),
3. “Мөнгөн гурвалжин-Картель” (Колумб, Болив, Перу, Мексикийн хилийн бүс нутаг),
4. “Хар гурвалжин” (Нигер, Гана, Кени, Судан, Өмнөд африк) гэх зэргээр нэрлэсэн байдаг байна.

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ,
ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДАЛ

Монгол Улсын хууль, эрх зүйн тогтолцоо

Монгол Улс Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцод 1990 онд, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын 1971 оны конвенцод 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцод 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцод 2008 онд тус тус нэгдэн орсон бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээдэг болсон.



Монгол Улс нь мансууруулах бодисын талаарх олон улсын санал, санаачилга болон үүрэг, зорилтыг хангахын төлөө хүчин чармайлт гаргаж ирсэн бөгөөд 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг баталж, 2002 онд баталсан Эрүүгийн хуульд дээрх төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг бий болгож, 2000-2005 онд “Хар тамхи, мансуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлжээ. (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017)

Дэлхий дахинд хүн худалдаалах, мансууруулах бодис наймаалах, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, түүх соёлын дурсгалт зүйлсийн хууль бус эргэлт, терроризм, хууль бус цагаачлал, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах гэмт хэргүүд байнга үйлдэгдэх болсон бөгөөд тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс олдог бохир мөнгө бүрдүүлдэг байна. Сүүлийн жилүүдэд БНХАУ, ОХУ болон Зүүн өмнөд Азийн орноос амфетамин, метамфетамин төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон бөгөөд цагдаа, хил, гаалийн байгууллагын мэдээллээс үзэхэд БНХАУ-аас ихэвчлэн амфетамин, метамфетамин төрлийн мөс (ICE) болон мансууруулах ургамлын гаралтай шавар (Hashish), ОХУ-аас сэтгэцэд нөлөөт “анданте” зэрэг эм хууль бусаар нийлүүлэх болжээ.


Иймд холбогдох хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг нь олон нийтэд ухуулан таниулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад хамтын ажиллагаа болон дотоодын мэргэжлийн байгууллага, салбар хоорондын оролцоог бэхжүүлэх, уялдуулах зорилгоор 2017-2021 оны хооронд хэрэгжүүлэх Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017 онд Засгийн газрын 77 дугаар тогтоолоор баталсан байна.

Дэлхийн эдийн засгийн байдалд крипто валютын хэрэглээ эрчимтэй хөгжиж, гэмт этгээдүүд нь зохион байгуулалтын нууц далд хэлбэрт шилжин, цахим сүлжээ ашиглан крипто валютаар гүйлгээ хийж, мансууруулах бодисын хууль бус эргэлтийг бий болгож, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Гадаад улсад түр хугацаагаар болон хууль бусаар оршин сууж буй Монгол Улсын иргэд (урьд өмнө хулгайлах, дээрэмдэх, залилах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт холбогдсон, шалгагдсан, ял шийтгэгдсэн) нь метамфетамин агууламжтай мөс гэх нэршилтэй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж, олон нийтийн цахим сүлжээ ашиглан бусдад худалдан борлуулж, виртуал хөрөнгө, 1xbet зэрэг цахим тоглоомын болон бусдын данс ашиглан төлбөрийг шилжүүлэн авч байгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус орлогыг тодорхойлох, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учирч байна.

Манай улсын нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал (каннабис)-ыг 2013 оноос хойш жил бүр устгах ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулсны үр дүнд 2019, 2021 онуудад хийгдсэн судалгаагаар Архангай, Ховд, Завхан аймгийн нутаг дэвсгэрт бүрэн устаж, үлдсэн 11 аймгийн 51 сумын 301 цэг байршил, нийт 4217 га талбайд уг ургамал ургаж байна. Уг ажилд зарцуулагдах төсвийг орон нутгийн санхүүжилтээр шийдвэрлүүлж байгаа нь цаашид устгалын арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэхэд төсөв санхүүгийн хувьд хүндрэл учруулж болзошгүй байна.

Мансууруулах бодис хэрэглэгч, донтогч иргэдийг эмчлэх эмнэлэг, тэдэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн эмч, үзүүлэх нийгмийн тусламж үйлчилгээ дутмаг, тус харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчин хангалтгүй байгаа нь хэрэглээг хумих, хэрэглэгчийн тоог хязгаарлах, хяналт тавих зорилгод сөрөг нөлөө үзүүлж, гэмт хэргийн гаралт нэмэгдэхэд нөлөөлж байна. (ЦЕГ, 2024)



Эрүүл мэндийн байгууллага нэгдсэн цахим мэдээллийн санг ашиглахгүй байгаагаас цаасан суурьтай мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг ашиглан нэгдсэн эмнэлэг, дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан мансууруулах эмийн жорыг давхардуулан бичүүлж, морфин, трамадол эмийг эмийн сангаас хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, худалдах гэмт хэрэг ихээр бүртгэгдэж байна.

Мансуурах зорилгоор конвенцын жагсаалтад ороогүй учир эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, үнэ хямд, олдоц элбэг, үйлчилгээ өндөртэй Тебантин (уналт таталтын өвчинд ихэвчлэн хэрэглэдэг булчин суллах үйлчилгээтэй), Лидокайн (хэсэг газрын мэдээгүйжүүлэлтэд хэрэглэдэг) зэрэг эмийг судсаар тарьж хэрэглэн халдварт өвчин (ХДХВ, Гепатит В, С вирус) авах, судас бөглөрч хуруу гар үхжих, тун хэтрүүлэн хэрэглэсний улмаас хүний амь нас хохирох тохиолдол мөн нэмэгдсээр байна.

Улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт болон өвчин намдаах үйлчилгээтэй энгийн эмийг урвуулан хэрэглэж хүний амь нас хохирсон тохиолдол 2022 онд 8, 2024 оны эхний 4 сарын байдлаар 1 бүртгэгдэж, үүнээс 5 иргэн нь Тебантин, Лидокайн гэх эмийг зохисгүй хэрэглэсний улмаас нас баржээ.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдаж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бусаар худалдаалах гэмт хэрэгт холбогдсон этгээдүүд нь цахим сүлжээ, крипто валютаар гүйлгээ хийж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг мөнгө угаасан гэмт хэрэгт давхар зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учруулж байна.

**МАНСУУРУУЛАХ ЭМ,
СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ
БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР
ХУДАЛДААЛАХ ГЭМТ
ХЭРЭГ МОНГОЛ УЛСАД**




Монгол Улсад тус гэмт хэргээр (ҮЭҮ) 2017-2019 байдлаар нийт 689 хэрэг нээн шалгасан байх бөгөөд яллах дүгнэлтийн хувьд нийт 432, шүүхийн шийтгэх тогтоолын хувьд 315 удаа тус тус үйлдэгдсэн байдалтай байна. Харин дээрх 681 хэргийн нийт хохирлын хэмжээ 557 саяд хүрсэн байна. Тус гэмт хэргээр 2017-2019 онд нийт 2 удаа мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэн 1 яллах дүгнэлт үйлдсэн тохиолдол бүртгэгдсэн байна.



Тус гэмт хэргийг нийт шалгасан хэргийн тоо болон хохирлын хэмжээнд үндэслэн мөнгө угаах гэмт хэргийн БАГА ДУНД эрсдэлтэй суурь гэмт хэргүүдийн тоонд оруулсан болно.

Харин сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2021-2023 онуудад Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах хэрэг 264-391 болтлоо өссөн байх бөгөөд жил ирэх тусам өсөх хандлагатай байна.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг БНХАУ, ОХУ гэсэн хоёр хөрш орноос эсхүл тэдгээрээр дамжин Малайз, Сингапур, АНУ зэрэг бусад орноос хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан гэмт үйлдлүүд бүртгэгдэж байна (ТЕГ, 2018). Хураагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, зүйлийн хувьд ихэвчлэн “каннабис, “ice” буюу мөс, “шавар”, “кокайн” байна.

Энэ төрлийн гэмт хэргийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхдээ цахим сүлжээ ашиглан захиалга өгөх, “карго”-оор тээвэрлэх, мөн бусдыг хууран мэхэлж тээвэрлүүлэх, үүндээ өөрсдийн гэр бүл, найз нөхөд, төрөл садангийн харилцаа холбоог ашиглах, гэмт хэрэгт татан оролцуулах, хил, гааль болон хууль хүчний бусад байгууллагуудын албан хаагчидтай үгсэн тохиролцох зэрэг арга хэрэглэж байгаа нь мансууруулах бодисын хууль бус эргэлтэд нөлөөлж буй гол хүчин зүйл болж, гэмт хэрэг үйлдэх нөхцөл боломжийг бий болгож байна.


Манай улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой далд байсан гэмт хэргийн санхүүжилт криптоны зах зээлээр дамжиж, Монгол Улсын дотоод аюулгүй байдал шууд заналхийлж байна. (Аюулгүй байдал судлалын хүрээлэн, 2021)

2010 оны НҮБ-ын тайланд дурдсанаар Монгол Улсыг хар тамхи мансууруулах бодис дамжуулан өнгөрүүлэгч улс гэж үзсэн байсан бол 2014 оны тайланд манай улсыг хэрэглэгч улс орон болсон гэж дүгнэсэн нь цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг анхааруулсан байна.

Гадаад нөхцөл байдал

ОХУ-аас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хил давуулж байгаад манай улс нэн тэргүүнд анхаарах шаардлагатай байна. Шалтгаан нь:

- ОХУ нь БНХАУ, Монгол Улстай өргөн зурвасаар хиллэдэг бөгөөд Афганистан, Пакистан, Турк, Иранд үйлдвэрлэсэн мансууруулах бодисыг тээвэрлэхэд ашигладаг хяналт шалгалтгүй тойруу замууд олон.



- Тус улсын өмнөд хилийн дагуу дэд бүтцийн хөгжил өндөр бөгөөд усан болон бусад тээврийн сүлжээгээр дамжуулан тээвэрлэж байна. Геройны хэмжээ өсөж байгаа нь дундаж үнэ Европын орнуудад Оросын зах зээл дээрхээс 2-4 дахин өндөр байдагтай холбоотой.

Латин Америкаас ОХУ-д кокайн нийлүүлэх ажиллагааг дагнан зохион байгуулдаг олон улсын бүлэглэлүүд ихэвчлэн Украин, ОХУ-ын далайн боомтуудыг ашигладаг байна. Энэ нь Европ руу агаарын тээврээр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис зөөхөд эрсдэл ихтэй, эдийн засгийн хувьд ашиггүй байгаатай холбоотой. Нөгөө талаас усан онгоцонд техникийн онцлогоос нь хамаарч их хэмжээний кокайн нуух боломжтой, гаалийн албад түүнийг илрүүлэхэд төвөгтэй байдаг нь мөн нөлөөлдөг.

Африкт хар тамхины гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхжиж, эдгээр бүлэглэлүүд гол төлөв героины худалдаа эрхэлж, орчин үеийн техник хэрэгслийг ашиглан илрүүлэхэд хүндрэлтэй нарийн аргыг үйл ажиллагаандаа ашигладаг. Ураг төрлийн холбоо бүхий гэмт бүлэглэлүүд хууль сахиулах байгууллагын хяналтад тэр бүр өртдөггүй байна. (С.Сүхчулуун, 2015)



Хятад улс хар тамхины асар том зах зээл бүхий улс орнуудтай хөрш зэргэлдээ оршдог бөгөөд үүнд Зүүн өмнөд Ази, Төв Азийн орнуудын хар тамхи үйлдвэрлэгч бүс нутгууд багтдаг байна. Түүнчлэн Хятадын нутгаар хар тамхи тээвэрлэн дамжин өнгөрөх гэмт хэргийн гаралт өргөжиж, хохирогчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. Тухайлбал, NHK телевизийн мэдээлснээр, Япон улсын 50 настай иргэн Хятадын Далянь хотод хар тамхи наймаалсан хэргээр цаазаар авах ял шийтгүүлсэн бөгөөд япон хүн Хятадад хар тамхины хэрэгт холбогдсон 5 дахь тохиолдол болжээ. Үүний зэрэгцээ Английн иргэн, Филиппиний 3 иргэн хууль бусаар бусдад хар тамхи худалдсан хэргээр цаазын ял сонсон шийтгүүлсэн байна.

Газарзүйн байрлалаас авч үзвэл Хятад нь улс төрийн тогтворгүй орнууд болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэгч хэд хэдэн улсуудаар хүрээлэгдсэн байдал, дүр зураг харагдаж байна. Гуадунгийн Улс төр, хуулийн сургуулийн судлаач Жан Сяовэйгийн үзэж байгаагаар:

- Гадаадын иргэд гол төлөв хувиараа болон гадны хар тамхины үндэстэн дамнасан гэмт бүлэглэлүүдтэй нэгдэх хэлбэрээр мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг Хятадын зах зээлд оруулж борлуулах, эсвэл хятадын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэж, бусад гуравдагч улс руу гаргаж байгаа.
- Үйл ажиллагааны хэлбэрээр нь авч үзвэл, сүүлийн жилүүдэд төрөл бүрийн эд зүйлс, хүнсний болон гоо сайхны бараа, техник хэрэгсэл, хүний бие дотор нууж агаарын боомтоор нэвтэрсэн тохиолдол өндөр хувийг эзэлж байна.
- Хар тамхи орж ирж буй чиглэлээс нь харахад өмнө нь ихэвчлэн Хятадын баруун өмнөд хэсгээр нэвтэрч байсан бол сүүлийн үед бүх мужийн нутаг дэвсгэрээр орж ирэх хандлагатай болж, түүнчлэн орж ирж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр төрөл ч олширсон.
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэгчдийн байдлаас харахад, Япон, Өмнөд Солонгосын иргэд мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Японы мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бизнес эрхэлдэг бүлэглэлүүд буюу якуза нар өндөр насны тэтгэвэрт гарсан настай иргэд эсвэл орон гэргүйчүүдийг ашиглан Хятадад героин, мөс зэргийг хууль бусаар борлуулах, мөн Япон руу гаргах зэргээр хоёр улсын хар тамхины зах зээлийн үнийн ялгааг ашиглан их хэмжээний ашиг олдог байна. (БНХАУ-ын Хар тамхины нөхцөл байдлын тайлан, 2020)

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шинэ төрөл нэмэгдэхийн хэрээр түүнийг таньж мэдэх, тодорхойлоход хүндрэлтэй болгодог. Одоогийн байдлаар БНХАУ-д 431 төрлийн эм бэлдмэл, фентанилийн бүхэл бүтэн ангиллыг жагсаасан байгаа боловч шинэ төрлийн мансууруулах бодис гарч ирсээр байна. Тухайлбал, “ЛСД агуулсан “Маркны хэлбэртэй цаас”, оюутнуудад зарж борлуулдаг ”Ухаалаг эм” №0 капсул”, ”Ж-цэгийн шингэн”, “Хирсний шингэн” зэрэг төрөл бүрийн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ аажмаар тархаж байна. БНХАУ-ын үндэсний лабораторийн мэдээллээр 2019 онд 41 сэтгэцэд нөлөөт бодис илрүүлснээс 4 шинэ төрлийн бодис илрүүлсэн байна.



Опиум, каннабисийн тархалттай тэмцэх ажил идэвхжиж, героины төрлийн бэлдмэл харьцангуй үнэтэй байдаг нь залуучуудын дунд эрэлт ихтэй эфедрон, первитин, катинон зэрэг синтетик гаралтай мансууруулах бодисын хууль бус үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн. Ийм төрлийн бодисыг гаргаж авах технологи нь хялбар, лабораторийн үнэтэй тоног төхөөрөмж шаарддаггүй, түүхий эдийн олдоц харьцангуй элбэг зэрэг нь цаашид энэ төрлийн бодисын үйлдвэрлэл улам өргөжнө гэсэн таамаглал дэвшүүлэхэд хүргэдэг байна.

Амфетамины төрлийн бодисыг хаа сайгүй хямдхан үйлдвэрлэдэг, үйлдвэр нь тогтмол байршлаа сольж байдаг аж. Ерөнхийдөө мансууруулах бодисын хууль бус наймаачид синтетик мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг их хэмжээгээр, хямд зардлаар газар зүйн байршлын хувьд хязгааргүй зөөж тээвэрлэдэг бөгөөд үүний дээр зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд үйлдвэрлэлийн ажиллагааг халхавчилдаг аж.

ТҮГЭЭМЭЛ ТИПОЛОГИУД

2020 оны байдлаар Монгол Улсын хилээр ОХУ-аас сэтгэцэд нөлөөт эм болон байгалийн гаралтай ургамал бодис, БНХАУ болон Зүүн өмнөд Азийн орнуудаас синтетик төрлийн бодисууд, АНУ болон Европын зарим улс орноос интернэт орчин, шуудан ашиглан, ачаа бараа, эд зүйлст нуун далдлах аргыг хэрэглэн, зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх явдал ихсэх хандлагатай байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис дараах урсгалаар манай улсад нийлүүлэгдэж байна. Үүнд:



БНХАУ болон Азийн орнуудаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тухайн орны болон гэмт этгээдүүдээр дамжуулан зуучлуулан худалдан авч, шуудан илгээмж, карго, хүнсний бүтээгдэхүүн, гоо сайхны бараа зэрэгт нуух аргаар улсын хил нэвтрүүлдэг.


ОХУ-аас орж ирдэг шинэ төрлийн мансууруулах бодисын зах зээл бий болсон. Манай улсын иргэд ОХУ-д чөлөөтэй зорчдогтой холбоотойгоор дээр дурдсан аргуудаар мөн улсын хил нэвтрүүлдэг байна.



Европын орнуудаас гол төлөв интернэт ашиглан мөс, гашиш, экстази, ЛСД зэрэг бодисыг худалдан авч, шуудан илгээмжээр тээвэрлэсэн зэрэг гэмт хэрэг бүртгэгджээ. (Аюулгүй байдал судлалын хүрээлэн, 2021)

Криптовалютын гүйлгээ нь нууцлал өндөртэй явагддаг. Нууцлал өндөртэй гүйлгээ хууль бус мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг далд зах зээлийг богино хугацаанд тэлэхэд үндсэн суурь болж байна. НҮБ-ын тайланд дурдсанаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын санхүүжилт далд хэлбэрт шилжиж байгаа бөгөөд криптовалют гарч эхэлснээс хойш донтогч нарын тоо идэвхтэй нэмэгдэх болсон гэв. (Cocaine Insights, 2021) “Алтан хавирган сар”, “Мөнгөн гурвалжин-Картель” гэж хэлэгддэг орнуудын далд зах зээлийн тодорхой санхүүжилт криптовалютаар хийгдэх болсон тухай АНУ-ын Хар тамхитай тэмцэх албаны 2020 онд гаргасан Мансууруулах бодисын зах зээлийн тухай тайланд дурдсан байна. (Үндэсний мансууруулах бодисын аюул, заналхийллын үнэлгээ, 2020)

Зураг 1. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эмийн санхүүжилт, далд зах зээлийн учир шалтгааны диаграмм



Монгол Улсад 2021 оноос криптовалютын зах зээл идэвхжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 2 орчим их наяд гаруй төгрөг эргэлдэж байгаа талаар Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээлсэн. Энэ их хэмжээний мөнгөний эргэлт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын далд зах зээлийг тэлж байх магадлалтай байна. 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын алба хаагчид хамтран Хятад улсаас хар тамхи оруулж ирдэг бүлэглэлийг илрүүлсэн бөгөөд төлбөрийг биткойноор хийсэн нь тогтоогдож байжээ.

Хятадын эрх баригчид криптовалютыг дотоодод гүйлгээнд ашиглах, олборлох ажлыг хориглож байгаа. Энэ үйлдэл нь хууль бус, далд зах зээлийг хумих, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээг хязгаарлах алхам юм. Харин Өмнөд Америкийн орнуудад криптовалютаар хийгдсэн байх магадлалтай хууль бус мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын санхүүжилт сүүлийн 3 жил 3-7 дахин өссөн гэх таамаглалыг Их Британийн цагдаагийн байгууллагаас 2020 онд танилцуулж байсан. Тус улсын Манчестер хотын цагдаагийн газрын эдийн засагтай тэмцэх хэлтсээс 2021 онд 6 сард 16 сая гаруй фунт стерлингтэй тэнцэх хэмжээний Ethereum криптовалюттай зөөврийн флаш дискийг гэмт этгээдүүдээс хураан авсан байв. Уг зөөврийн флаш диск дээр байрлах криптовалютаар их хэмжээний мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг гэмт этгээдүүд худалдаж авахаар төлөвлөж байсан байна.

МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН НАЙМААЧИД МӨНГӨӨ ХААНА НУУДАГ ВЭ?

Мансууруулах бодисын наймааны салбар дахь мөнгө угаах үйл явцын өргөн хүрээг мэдэж, ойлгох нь чухал. Global Financial Integrity-ийн “Үндэстэн дамнасан гэмт хэрэг ба хөгжиж буй дэлхий дахин” тайланд дурдсанаар, дэлхийн хууль бус хар тамхины зах зээл зөвхөн 2014 онд л гэхэд 426-652 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь хар тамхины наймаачид ямар их хэмжээний мөнгө угааж байгааг харуулж байна. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын картелууд нь дэлхийн санхүүгийн зах зээлд интернэт төлбөрийн платформ, криптовалют, төлбөрийн карт, үл хөдлөх хөрөнгө гэх мэт янз бүрийн төлбөрийн хэрэгсэл, арга ашиглан ашиг орлогоо нуун дарагдуулдаг. Үүний дараа тэд угаасан бэлэн мөнгөө наймаа хийхдээ ашигладаг байна. (How drug dealers launder money?, 2020)

Угаах хөрөнгийн хэмжээ их байгаа нь хар тамхины бүлэглэлүүдийг сэжиглэхгүй байх нөхцлийг бүрдүүлдэг. Иймээс асар том хэмжээний гэмт хэргийн үйл ажиллагаа нь гэмт бүлэглэлд шууд холбогдсон хүмүүсийг хохироохоос гадна санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд нөлөөлж, хар тамхины өргөн хэрэглээг хөхүүлэн дэмждэг сөрөг үр дагавартай байна.

БОХИР МӨНГИЙГ ЦЭВЭРЛЭХ ҮЕ ШАТУУД

Байршуулах

Энэ үе шатанд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын наймаачид хууль бусаар олсон орлого, мөнгө хөрөнгөө хууль ёсны санхүүгийн байгууллагад нэвтрүүлэхийг оролддог. Учир нь энэ төрлийн гэмт хэргийн замаар олсон мөнгөн хөрөнгө нь анхаарал татахуйц хэмжээ, онцлог шинжтэй байхаас гадна хөрөнгө, орлого нь гэмт хэрэгтнүүдийн ажил, бизнес, профайлтай нийцээгүй байдаг тул хар тамхины наймаачид хууль бус хөрөнгө мөнгөний эх үүсвэрээ хууль сахиулах байгууллагын хараа хяналтаас холдуулах, нуун дарагдуулах зорилгоор олон жижиг хэсэгт хувааж смурфинг (smurfing) хийх, халхавч компани ашиглах, худалдаанд суурилсан хэлбэр, их хэмжээний бэлэн мөнгө хууль бусаар хил давуулах гэх мэт янз бүрийн арга хэрэглэдэг.


Нуун далдлах

Нуун далдлах зорилго нь хууль бусаар олсон мөнгөний дийлэнх хэсгийг багасгаж, тэдгээрийг өөр өөр дүнтэй олон жижиг гүйлгээ болгох замаар ялгаатай байршилд шилжүүлэх явдал юм. Ингэхдээ хэд хэдэн арга ашиглаж болно. Тухайлбал, цахим шилжүүлэг хийх, гадаадын буюу оффшор бүс дэх банкны данс руу шилжүүлэх, халхавч компани ашиглах гэх мэт. Түүнчлэн гадаадын зах зээлд хувьцаа арилжих байдлаар хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах боломжтой.

Буцаан төвлөрүүлэх

Энэ үе шат нь мөнгө угаах үйл явцын эцсийн шат бөгөөд тухайн хууль бус хөрөнгө нь санхүүгийн системийн нэг хэсэг болж, угаасан мөнгийг эдийн засагт "хууль ёсны" болгон буцааж төвлөрүүлэх боломжийг олгодог. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын наймаачид энэ үе шатанд угаасан мөнгөө хууль ёсны орлого болгон ашиглах боломжтой. Тэд хууль бусаар олсон мөнгөө эрх бүхий байгууллагуудын анхаарлыг татахгүй, сэжиг төрүүлэхгүй байхуйц тансаг зэрэглэлийн эд хөрөнгө, эд зүйл, үл хөдлөх хөрөнгө худалдаж авахад зарцуулж болзошгүй юм.

Зураг 2. Мөнгө угаах үе шат



Буцаан төвлөрүүлэх үе шатанд хууль бус буюу бохир мөнгө олон үе шат, дамжлага, хууль ёсны арга хэрэгслээр дамжсан байдаг тул мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эх үүсвэрийг эргүүлэн олж тогтоох нь хууль сахиулах байгууллагуудын хувьд ихээхэн хүндрэл учруулдаг. Бохир мөнгийг цэвэр болгохдоо ашигладаг зарим нийтлэг арга, техникийг дор дурдав. Үүнд:

Бэлэн мөнгийг хууль бусаар хил нэвтрүүлэх

Энэхүү арга нь одоо үед ихээхэн газар авч байгаа бөгөөд бэлэн мөнгийг өөр улс руу биечлэн шилжүүлэх/байршлыг солих, тэнд байрлах банк, санхүүгийн байгууллагад байршуулах арга юм. Мөнгө шилжүүлэх ажлыг хөнгөвчлөхийн тулд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын наймаачид нь тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани эсвэл хувь хүнийг ашиглах тохиолдол байдаг.

Мөнгийг жижиг хэсгүүд болгон хуваах (smurfing & structuring)

Энэ аргыг ашиглахдаа нийт бэлэн мөнгөний гүйлгээг хуульд заавал мэдүүлэх ёстой гэж заасан босго дүн (жишээ нь, МУ-д 20,000,000 төгрөг), түүнтэй тэнцэх гадаад валютаас доогуур хэмжээгээр хуваадаг. Энэхүү үйлдлийг хэд хэдэн санхүүгийн байгууллага дээр очиж хийж буй хүмүүсийг (smurf) гэж нэрлэдэг.

Цахим шилжүүлэг

Бохир мөнгийг цахимаар шилжүүлэхэд хувь хүн, хуулийн этгээд болон дансыг ашигладаг. Мөнгө угаах үйл явцын бүх үе шатанд, ялангуяа нуун далдлах үе шатанд цахим шилжүүлэг нь үндсэн арга хэрэгсэл болж ашиглагдсан хэвээр байна. Хууль бус хөрөнгийг өөр өөр улс орнуудад байрлах өөр өөр санхүүгийн байгууллагаар дамжуулснаар тухайн хууль бус хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдалж, гэмт хэргийн замаар олсон бохир эх үүсвэрээс нь холдуулах зорилгоо гүйцэлдүүлдэг.

Халхавч компани

Мөнгө угаахын нуун далдлах үе шатанд бохир мөнгө, хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, өөрчлөх, шилжүүлэх, хувиргах зорилгоор санхүүгийн бусад хөрөнгө, хэрэгслийг худалдаж авахын тулд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын наймаачид нь халхавч компаниуд ашигладаг. Ингэснээр тус мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, гадаад худалдааны бизнес хийж буй дүр эсгэх, гадаад улсын харьяалалд буй банкны дансанд мөнгөө хадгалах гэх мэтээр ашиглах боломжтой.

Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ

СМА-дад мансууруулах бодис тээвэрлэхтэй холбоотой СГТ-г мэдээлж буй хамгийн чухал мэдээллийн эх үүсвэр нь санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нар юм. СГТ-тай холбоотой статистик мэдээлэл гаргадаг зарим улс, орнууд тэдгээрт маш цөөн тооны хууль бус синтетик мансууруулах, сэтгэгцэл нөлөөт бодистой холбоотой сэжигтэй гүйлгээнүүд мэдээлэгдсэн талаар дурдсан байна. (ФАТФ, 2022).

Синтетик опиодтой холбоотой СГТ цөөхөн байгаагийн шалтгаан нь магадгүй, улс орнууд хүлээн авч буй СГТ-гаа яг тухайлсан төрлийн мансууруулах бодистой холбоотой гэсэн шалгуур үзүүлэлтээр ангилдаггүйтэй холбоотой байж болох юм.

Монгол Улсын хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2021-2023 оны хооронд СМА нь МҮЭ-ээс “Хар тамхитай холбоотой байж болзошгүй” гэсэн сэжиглэх үндэслэлээр нийт 7 СГТ-г хүлээн авсан байна. МҮЭ энэ төрлийн сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд яг ямар төрлийн мансууруулах бодис болохыг ялгаж мэдээлэх боломжгүй байхын зэрэгцээ эдгээр мэдээлсэн СГТ-уудын ихэнх нь хууль сахиулах, прокурорын байгууллагаас хүргүүлсэн албан бичиг, шийдвэр хүлээн авсантай холбогдуулан мэдээлсэн СГТ-ууд байв.

Дижитал төлбөрийн платформууд болон ВХҮҮ

ФАТФ-аас ВХ болон ВХҮҮ-ийн тухай шинэчилсэн стандартын хүрээнд гаргасан тоймд мэдээлснээр, МУТС-тэй тэмцэж буй арга хэмжээ нь дэлхий дахинд харилцан адилгүй хэвээр байгаа хэвээр байна. ВХҮҮ-дэд эрсдэлийн нөхцөл, эмзэг байдлыг илүү сайн ойлгохын тулд тодорхой зааварчилгаа өгөхийг олон улсууд нэн тэргүүнд тавьдаг бөгөөд ингэснээр янз бүрийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд, тэр дундаа хар тамхины наймаачид энэ төрлийн үйлчилгээг урвуугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх боломжтой юм. Виртуал хөрөнгийн гүйлгээ болон түүнтэй холбоотой эрсдэл, эрсдэлийг тодорхойлогч үзүүлэлтүүдийг үнэлж чаддаг байх нь сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг тодорхойлох чухал хүчин зүйл юм.

Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, алан хядах болон бусад гэмт хэргийн үйл ажиллагаа ихтэй улс орнуудаас эсвэл тэдгээртэй холбоотой хууль бус хар тамхи, хүний наймаа, хууль бус мөрийтэй тоглоомын эх үүсвэрийг дамжин өнгөрүүлж буй улс, эсвэл ямар нэг хориг, хязгаарлалтад орсон улс, эсвэл МУТС өндөр эрсдэлтэй улс, орнуудаас ВХ-ийн шилжүүлэг хүлээж авч байгаа тохиолдолд харилцагчийн таньж мэдэх нарийвчилсан арга хэмжээ авах нь зүйтэй.

Түүнчлэн ВХ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ, хүргэлтийн сувагтай холбоотой эрсдэлтэй хүчин зүйлсүүд байж болох бөгөөд тус үйл ажиллагаа нь хуурамч эсвэл нэргүй гүйлгээ, нүүр тулсан бус бизнесийн харилцаа, гүйлгээ, болон/эсвэл үл мэдэгдэх харилцагч эсвэл холбоо хамааралгүй гуравдагч этгээдээс төлбөр хүлээн авах байж болно.

*Жишээ 1. Трамадолын хууль бус наймаа болон мөнгө
угаах үйл ажиллагаа*

ХБННУ-ын цагдаагийн байгууллагаас трамадолын наймаатай холбоотой хэргийг Үндэсний хар тамхины хууль сахиулах агентлагт шилжүүлжээ.

Албаныхан хууль бусаар зарж борлуулах зорилгоор авч явсан 200 хайрцаг трамадол эмийг хураан авсан нь өндөр түвшний наймаачныг мөшгиж олоход нөлөөлсөн байна. Нигерийн Санхүүгийн тагнуулын албатай зөвлөлдсөний дараа хийсэн дүн шинжилгээгээр тус наймаачин нь банкны 103 данстай холбоотой болохыг тогтоожээ. Үүнд:

- 10 хувийн данс;
- 103 байгууллагын данс (хувьцаа эзэмшдэг байгууллагууд)

Мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэн нь хууль бусаар худалдаалах зорилгоор хэд хэдэн тээвэрлэлтийн чингэлэг дүүрэн трамадол оруулж ирсэн нь тогтоогдсон байна.

Эдгээр дансууд нь ам.доллар, Британийн фунт стерлинг зэрэг хэд хэдэн өөр валютын данснууд байсан бөгөөд үл хөдлөх хөрөнгө худалдан авах замаар банкны данс болон зээлийн бүтээгдэхүүнийг ашиглан гэмт хэргээс олсон орлогыг нуун дарагдуулж байсан байна. Тухайлбал, ХБННУ-д нийт 72 өөр үл хөдлөх хөрөнгө худалдан авсан байжээ.


Одоогоор хэргийг шалгаж байгаа төдийгүй хөрөнгө, банкны дансыг бүгдийг нь битүүмжилж, эд хөрөнгө хураах ажиллагааг эхлүүлсэн байна. Мөн энэ хэрэг нь мөнгө угаасан, хар тамхи зөөвөрлөсөн хэргээр баривчлагдаж, яллагдагчаар татагдсан цагдаагийн албан тушаалтнуудын өндөр түвшний авлигын хэргийг илрүүлэхэд хүргэжээ.

Жишээ 2. Сэжигтэй гүйлгээгээр урьдал бодисын худалдан авалтыг тодорхойлсон нь

Сэжигтэй төлбөрийн арга, хэрэгслүүд нь банканд фентанил үйлдвэрлэхэд ашигласан хууль бус химийн бодисын худалдан авалтыг илрүүлэхэд хэрхэн туслалцаа үзүүлдэг болохыг дараах жишээгээр онцлон харуулав.

Энэхүү зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл нь Ази тивийн химийн үйлдвэрээс захиалсан олон арван төмөр утсыг худалдан авах зорилгоор хэд хэдэн хувь хүмүүсээр хуульд заасан босго дүнгээс доогуур дүнгээр бэлэн мөнгөний гүйлгээ хийлгүүлсэн байна. Банк энэхүү төлбөрийн хэвийн бус хэв шинжийг ажиглан, холбогдох бүх хүмүүсийн нэр дээр сэжигтэй гүйлгээний мэдээлэл илгээжээ. Эдгээр хүмүүс нь фентанил үйлдвэрлэсэн хэргээр шалгагдаж байсан байх бөгөөд фентанил үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд их хэмжээний урьдал бодисууд шаардлагатай байдаг байна.

Зураг 3. Сэжигтэй гүйлгээгээр урьдал бодисын худалдан авалтыг тодорхойлсон нь




Жишээ 3. Онлайн эмийн компани болон XCMU ашигласан нь – Энэтхэг Улс

Энэтхэгийн Татварын тагнуулын байгууллага (DRI) нь найдвартай эх сурвалжаас мэдээлэл хүлээн авсан бөгөөд "Х" нь хар тамхины төрлийн фентанил HCL-ийг цааш гадаадын иргэдэд нийлүүлэх зорилгоор хууль бусаар үйлдвэрлэдэг байжээ. Фентанилыг Индор дахь "Ү" хүн хууль бусаар ажиллуулдаг лабораторид үйлдвэрлэдэг байсан байна. Гадаадын нэг иргэн Индор хотод айлчилдаг байсан нь "Х" болон "Ү" нь энэхүү гадаадын хамсаатантай (Мексикийн иргэн) фентанил HCL-ийн их хэмжээний илгээмжийг нийлүүлэх/хууль бусаар хил нэвтрүүлэхтэй холбогдуулан уулзалт хийх зорилготой байжээ.

Дараа нь үйлдвэрлэсэн фентанилыг АНУ-д борлуулахаар Мексик рүү зөөж, мөнгө нь Хонг Конг дахь ноён Х-ийн компанийн банкны данс руу Мексикээс орж ирдэг байсан байна. Энэ мөнгийг Энэтхэг рүү буцааж оруулахын тулд ноён Х Азийн өөр улсаас бараа бүтээгдэхүүн импортолдог янз бүрийн импортлогчидтой холбогдож, тэдний импортын барааг Энэтхэгийн гаалийн байгууллагад доогуур дүнгээр мэдүүлж гаалийн хяналтаас зайлсхийдэг байжээ. Хэдий хяналтаас зайлсхийхийг оролддог байсан ч эдгээр импортлогчид нь холбогдох төлбөрөө банкны сувгаар дамжуулан Азийн нөгөө улс руу шилжүүлдэг байсан байна. Ноён Х эдгээр барааны зөрүүг (зөрүү дүн=барааны бодит үнэ – гаальд мэдүүлсэн барааны үнэ) Хонг Конг дахь данснаасаа экспортлогч руу шилжүүлдэг байна. Энэтхэгийн эдгээр импортлогчид нь түүнд тэрхүү мөнгийг нь бэлнээр Энэтхэгт төлдөг байж.

Эрх бүхий байгууллагууд нь хууль бусаар тээвэрлэж явсан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, борлуулалтын орлого болох 8,600 ам.доллар, тээврийн хэрэгслийг хураан авчээ.

Зураг 4. Онлайн эмийн компани болон XCMU ашигласан нь – Энэтхэг Улс



Жишээ 4. Хар тамхины наймаа болон мөнгө угаах гэмт хэрэгт санхүүгийн байгууллагуудыг урвуулан ашигласан нь – Арабын Нэгдсэн Эмират Улс


АНЭУ-ын СМА нь хөнгөн тээврийн хэрэгслийн жолоочоор ажилладаг Иргэн А-гийн нэр дээр сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авчээ. Мэдээлэх болсон шалтгаан нь тухайн харилцагч АНЭУ дахь янз бүрийн байршил дахь үл мэдэгдэх хүмүүсээс АТМ-ээр дамжуулан хэд хэдэн удаа бэлэн мөнгөөр орлого хүлээн авч, дараа нь өөр өөр хүн рүү мөнгө шилжүүлсэн байна. АНЭУ-ын СМА-наас Иргэн А-тай холбоотой хийсэн дүн шинжилгээгээр сэжигтэй гүйлгээний хэв маяг нь хар тамхины наймаа, мөнгө угаахтай холбоотой байж болзошгүйг илтгэх хэв маягтай нийцэж буйг илрүүлсэн. Дүн шинжилгээгээр мөн Иргэн А-ийн гол хамтрагчид болох гэмт хэргийн бүлэглэлийн гишүүн байж болзошгүй гэж сэжиглэгдсэн Иргэн Б, Иргэн В, Иргэн Г-г илрүүлсэн байна. Эдгээр 4 иргэд нь өөр өөр мэргэжлээр ажилладаг бөгөөд тэдний хоёр нь ижил иргэншилтэй бусад нь өөр өөр иргэншилтэй байжээ.

Иргэн Б нь шивэх үйлчилгээ үзүүлдэг С компанийн хамтрагч, мөн аялал жуулчлалын агентлагийн эзэмшигч болох нь тогтоогдсон. Иргэн Б нь хоёр банканд харилцах болон хадгаламжийн данс эзэмшдэг, өөр өөр биржүүдэд мөн гурван данс эзэмшдэг аж. Дээр дурдсанаас өөр нэг МҮЭ-ээс Иргэн Б нь банк хоорондын шилжүүлэг болон бэлнээр их хэмжээний мөнгө хүлээн авч, шууд бэлнээр зарлагдах эсвэл гуравдагч этгээд руу шилжүүлж байгааг СГТ-аар илгээсэн байна. Түүнээс гадна Иргэн Б нь мөн цэвэрлэгээний үйлчилгээ эрхэлдэг Х компанийн нэр дээр ирүүлсэн СГТ-тай холбоотой байв. Тус компани нь өөр өөр хүмүүсээс их хэмжээний бэлэн мөнгө хүлээн авч, дараа нь бэлнээр зарлагддаг байна. Банкнаас хийсэн ХТМ үйл ажиллагааны үр дүнд Иргэн Б нь С компанийн нэрээр нэхэмжлэх гаргаж өгсөн нь хуулийн этгээдийг хууль бус зорилгоор урвуулан ашигласан гэх хардлагыг төрүүлжээ.

Өөр нэг МҮЭ нь хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн лавлагаа мэдээлэл авах хүсэлтийг үндэслэн Иргэн В-ийн нэр дээр СГТ мэдээлжээ. Иргэн В-ийн дансны үйл ажиллагаа нь банканд мэдүүлсэн баримт бичиг болон данс нээлгэх зорилгоос зөрүүтэй байсан бөгөөд ямар нэг цалингийн орлого хүлээж авсан мэдээлэл байхгүй байсан болно. Иргэн В нь бага цалинтай мужаанаар ажилладаг байсан ч их хэмжээний бэлэн орлого хүлээн авсны дараа шууд зарлага гарган, дансандаа бага үлдэгдэлтэй үлддэг байжээ. МҮЭ гүйлгээг тодруулах гэж хэд хэдэн удаа оролдсон хэдий ч Иргэн В хангалттай тайлбар өгч чадаагүй байна. Цаашлаад Иргэн В нь их хэмжээний бэлэн орлого хийж, бусад харилцагч руу шилжүүлэг хийх замаар өөр санхүүгийн байгууллагад данс эзэмшдэг байсан нь тогтоогджээ.

Иргэн Г нь Иргэн А-аас их хэмжээний мөнгө хүлээн авч, дараа нь шууд бэлнээр зарлага гаргадаг болох нь тогтоогдсон. Эцэст нь АНЭУ-ын СМА-наас уг хэргийг холбогдох хууль сахиулах байгууллагад шилжүүлжээ.

Зураг 5. Хар тамхины наймаа болон мөнгө угаах гэмт хэрэгт санхүүгийн байгууллагуудыг урвуулан ашигласан нь – Арабын Нэгдсэн Эмират Улс



АВАХ

арга хэмжээ

Улс орнууд ФАТФ-ын зөвлөмжийг эрсдэлд суурилсан аргачлалаар дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

ФАТФ-ын зөвлөмж буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын наймаанаас олсон орлогын асуудлыг шийдвэрлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй тогтолцоо юм.

- ❖ Эрсдэлийн ойлголтыг нэмэгдүүлэх
- ❖ Санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагааг сайжруулах
- ❖ Дотоод хамтын ажиллагааг сайжруулах
- ❖ Хувийн хэвшлийн оролцоо болон төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих

